



Үндэсний геологийн албаны 2025 оны
01 дүгээр сарын 27 өдрийн
1/27 тоот албан бичгийн хавсралт

**ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНЫ АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН
БАТАЛГААГ ХАНГАХ 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

№	Үйл ажиллагааны чиглэл	Зохион байгуулах ажил	Хэрэгжилт
1	Ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлэх чиглэлээр	Ажилтан ажил үүргээ хэвийн гүйцэтгэхэд шаардлагатай компьютер, эд хөрөнгөөр хангах, зайлшгүй шаардлагатай техник хэрэгслийг захиалж, ажилтныг хэвийн ажиллах нөхцөлөөр хангах /Компьютер, скайнер, камер, сейф, ажлын хувцас, багаж төхөөрөмж г.м/	<p>Албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор нийт 353.8 сая.төг зарцуулсан. Энэхүү зардал нь УГА-ны 2024 оны төсөвт АҮЭБЯ-наас нэмэлт зохицуулалт хийж санхүүжүүлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Судалгааны ажлын багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж – 27.4 сая.төг ✓ Ажлын хувцас – 39.6 сая.төг ✓ Хэвийн бус нөхцөлийн нэмэгдэл /сүүний/ зардал - 7.8 сая.төг ✓ Шинээр төрсөн 3 хүүхэд – 1.5 сая.төг ✓ Үр дүнгийн урамшуулал – 68.3 сая.төг ✓ Балансын урамшуулал 2.5сая.төг
2	Тусламж дэмжлэгийн чиглэлээр	Ажилтан шинэ гэр бүл болох, хүүхэдтэй болох, баярт үйл явдал, гачигдал тохиолдсон үед журмын дагуу шийдвэр гаргах, дэмжлэг тусламж үзүүлэх	<p>2024 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн Б/10 дугаар тушаалаар нийт 28 албан хаагчийн ээлжийн амралтын хуваарийг баталж, хуваарийн дагуу амралтыг биеэр эдлүүлсэн. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй 3 албан хаагчид хөдөлмөрийн тухай хуулийн 110 дугаар зүйлийн 110.2 дахь хэсэгт заасны дагуу 1.5 хувиар тооцон нэмэгдэл олгосон.</p> <p>Тусламж, дэмжлэг хүссэн:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Түлээ нүүрсний хөнгөлөлтийг 2 албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламжаар 7зуун мянган. төгрөг ✓ Шинээр хүүхэдтэй болсон- 3 албан хаагчид 1.5 сая.төгрөг ✓ Буцалтгүй тусламж хүссэн 2 албан хаагчид 1. сая.төгрөгийн тусламж дэмжлэг тус тус үзүүлсэн.
3		Өндөр насны тэтгэвэрт гарах ажилтан албан хаагчид, Хөдөлмөрийн дотоод журам болон Албаны ахмадын хорооны журмын дагуу холбогдох дэмжлэг үзүүлэх	<p>Төрийн албаны тухай хуулийн дагуу нэг удаагийн тэтгэмж болох 25.948.900 /хорин таван сая есөн зуун дөчин найман мянга есөн зуун төгрөг/- ийг тус албаны Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн Ахлах мэргэжилтэн Б.Мөнхтуяад 2024 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн Б/52 дугаар тушаалаар шийдвэрлэсэн.</p> <p>Албаны ахмадын хорооны журмын 3.2.2-т заасны дагуу 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн Б/07 дугаар тушаалаар ахмад албан хаагч О.Чулуунд 1.0 сая.төгрөгийн тэтгэмж олгосон.</p> <p>Ахмадын өдрийг тохиолдуулан ахмадуудад хүндэтгэл үзүүлсэн.</p>

4	2024 оны сургалтын төлөвлөгөө"-г Албаны даргаар батлуулж, батлагдсан төлөвлөгөөний дагуу албан хаагчдыг сургалтад жигд хамруулах	2024 оны сургалтын төлөвлөгөөг нэржүүдийн хэрэгцээ шаардлага саналыг үндэслэн боловсруулж, агентлагийн даргаар батлуулсан. Төлөвлөгөөг сургалтууд цахимаар болон танхимаар зохион байгуулагдсан. Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх нийт 18 сургалтын хүрээнд 30 албан хаагч /давхардсан тоогоор 136/ бүрэн хамрагдсан. Сургалтын дэлгэрэнгүй мэдээлэл бүртгэлийг хавсаргаав.
5	Албан хаагчдын сургалт хөгжлийн чиглэлээр	Удирдлагын академийн Төрийн албаны сургуулийн мэргэшүүлэх сургалтууд танхимаар болон цахимаар зохион байгуулагдан хамрагдсан. Тэргүүн түшмэлийн багц сургалт- 1, Эрхэлсэн түшмэлийн багц сургалт-2, Ахлах түшмэлийн багц сургалтад- 1, Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалт-2, Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх сургалт-2 нийт 8 албан хаагч хамрагдаж албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан тусгай шаардлага шалгуурыг хангасан.
6		2024 онд шинээр томилогдсон албан хаагчдад байгууллагын дотоод журам болон төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэмтэй танилцах зааварчилгаа өгч ажилласан. Байгууллагын дотоод журмыг дотоод сүлжээнд, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг байгууллагын цахим хуудсанд тус тус байршуулж, нийт албан хаагчид танилцах нээлттэй боломжийг бүрдүүлсэн.
7		Албан хаагчдыг эрүүл мэндийн даатгалд хамруулах
9		Нийт албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах
10	Ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах, чөлөөт цагийг үр ашигтай өнгөрөөх чиглэлээр	АШУҮИС-ийн Монгол-Японы эмнэлэгтэй байгуулсан 2024 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх гэрээний дагуу нийт албан хаагчдыг эрүүл мэндийн нарийвчилсан үзлэг шинжилгээнд хамруулсан.
10		Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Албаны даргын 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/25 дугаар тушаалаар албан хаагчдын 52 хүүхдэд бэлэг өгөх ажлыг зохион байгуулсан. Шинэ жилийн баярыг тохиолдуулан 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/74 дугаартай тушаалаар 0-16 насны 57 албан хаагчдын хүүхдүүдийн дунд гар зургийн бүтээлийн уралдаан зарлаж, шагналт байрт шалгаруулан, хүүхэд бүрт шинэ жилийн бэлэг өгсөн.
10		Хүндээр өвчилсөн болон хүнд өвчний улмаас гадаад улсад өндөр төлбөртэй эмчилгээ, сувилгаанд явах шаардлагатай албан хаагчдад хандив, туслалцаа үзүүлэх

Тайлбар: Төрийн албаны тухай хууль, хөдөлмөрийн тухай хуульд албан хаагчдын нийгмийн баталгааг хангах асуудлыг хөдөлмөрийн дотоод журамд тусган хэрэгжүүлэхээр заагдсан хэдий ч байгууллагын 2024 оны төсөвт уг төрлийн зардал огт тусгагдаагүй тул дээрх арга хэмжээг байгууллагын дотоод нөөц бололцоо, АУЭБЯ-нд уламжлан нэмэлт зохицуулалтаар зохиох түвшинд хэрэгжүүлсэн.